

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛИЙН ТӨСӨЛД
ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2026

ГАРЧИГ

УДИРТГАЛ.....	3
НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО	3
1.1. Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох.....	3
1.2. Зардлын тооцоо.....	4
1.3. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах	6
1.4. Үр дүн, санал	6
ХОЁР. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО	7
2.1. Төрийн байгууллагад хүлээлгэсэн үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлох	7
2.2. Ажил, үйлчилгээ гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох.....	8
2.3. Зардлын тооцоо.....	9
2.4. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах	11
ГУРАВ. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО.....	10
3.1. Иргэнд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох	10
3.2. Зардлын тооцоо.....	11
3.3. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах	12
3.4. Үр дүн, санал	12
НЭГДСЭН ДҮГНЭЛТ	12
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	13

УДИРТГАЛ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал” (цаашид “Аргачлал” гэх)-ын дагуу тооцоолов.

Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор боловсруулсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлж эхэлснээр уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, түүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдсэн болно.

НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцохдоо хуулийн этгээдийн зүгээс тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх хүрээнд хийх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг¹ тодорхойлж, тус бүрд нь зарцуулах зардал, хугацаа² болон ажлын хөлсийг тогтоов.

Зардлын тооцоог дараах алхмын хүрээнд хийнэ. Үүнд:

1. Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох;
2. Зардал тооцох;
3. Тоон үзүүлэлтийг тооцох;
4. Зардлын дүнг тооцож гаргах.

1.1. Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох

Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг³ тогтоохдоо хуулийн үйлчлэлд хамрагдах хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн зүйл, заалтыг үндэслэсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт зааснаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч хувийн болон мэргэжлийн бусад байгууллага, иргэнээр гэрээлэн гүйцэтгүүлж болох, 38.3.3-т зааснаар хууль тогтоомж, гэрээнд заасан бол энэ хуулийн 5.1.2-т заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг үзүүлж болох үүргийг хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагад хүлээлгэсэн байна.

2026 оны 6 дугаар сарын байдлаар хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага буюу хөдөлмөрийн бирж 63 байна. Эдгээр байгууллагыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ үзүүлэх болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ зохион байгуулахад гэрээний үндсэн дээр татан оролцуулах зохицуулалт тусгагдсан.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2-д дурдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг гэрээний дагуу гүйцэтгэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч хувийн болон мэргэжлийн бусад

¹ Үүрэг тус бүрийг гүйцэтгэхэд зайлшгүй хийгдэх үйлдлийг стандарт үйл ажиллагаа гэнэ.

² Хуулийн этгээдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хугацааг тогтоохдоо Засгийн Газрын 2006 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын Хүснэгт 1-ийг ашигласан.

³ Гүйцэтгэх үүрэг гэж тухайн хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд хуульд заасны дагуу тоо баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг хэлнэ (Засгийн Газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалын 2.3).

байгууллагад зохих жишиг тарифын дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төлнө.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага болон бусад мэргэжлийн байгууллагад үүрэг хүлээлгэсэн дараах зохицуулалт байна.

Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч хувийн болон мэргэжлийн бусад байгууллагад үүрэг хүлээлгэсэн байдал

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Үүрэг
38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэг	Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эсхүл аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг шаардлага хангасан, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоонд бүртгүүлсэн хувийн, мэргэжлийн бусад байгууллага, иргэнээр гэрээлэн гүйцэтгүүлж болно.
38 дугаар зүйлийн 38.2.2 дахь заалт	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны гэрээлэн гүйцэтгэгчийн гүйцэтгэлийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоогоор дамжуулан хянаж, гэрээний хэрэгжилтийн үнэлгээнд тулгуурлан холбогдох төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.
38 дугаар зүйлийн 38.2.3 дахь заалт	Гэрээний шаардлагыг хангаагүй гэрээлэн гүйцэтгэгчийн төлбөрийн олголтыг түтгэлзүүлэх, холбогдох бүртгэл, эрхийг хүчингүй болгох, худалдан авах ажиллагаанд оролцох эрхийг хасах зэрэг хариуцлага хүлээлгэж болно.
38 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Энэ хуулийн 38.1-д заасан хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага нь хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эсхүл түүний эрх олгосон байгууллагад бүртгүүлсэн, иргэн төвтэй, хувь хүнд чиглэсэн кейс менежментэд тулгуурласан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг үзүүлэх төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллага байна.
38 дугаар зүйлийн 38.3.1 дэх заалт	Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагыг бүртгэх, бүртгэлийг сунгах үйл ажиллагааг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон үйлчилгээний стандарт, гүйцэтгэлийн үнэлгээ, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн байдалд үндэслэн хэрэгжүүлнэ.
38 дугаар зүйлийн 38.3.2 дахь заалт	Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага хууль тогтоомж, гэрээнд заасан бол энэхүү хуулийн 5.1.2-т заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын хяналт, мэргэжил, арга зүйн удирдлагын дагуу хэрэгжүүлж болно.
38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч хувийн болон мэргэжлийн бусад байгууллага, иргэнд тавигдах шаардлага, түүнийг бүртгэх, гэрээ байгуулах, үйл ажиллагааны гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, санхүүжилт олгох журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

1.2. Зардлын тооцоо

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр хуулийн этгээдэд үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцоолж гаргав. Хуулийн этгээдийн зүгээс тухайн үүргийг хэрэгжүүлэх хүрээнд хийх үйлдэл буюу

стандарт үйл ажиллагааг тодорхойлж, тус бүрт зарцуулах хугацаа болон ажлын хөлсийг нь тогтоосон.

Зардлыг тооцохдоо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

1. Үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлох;
2. Тухайн үйлдэлд зарцуулагдах хугацааг тогтоох;
3. Тухайн үйлдлийг хийх ажилтны ажлын хөлсийг тодорхойлох.

Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлыг тооцохдоо стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэсэн.

Ажлын хөлсний тооцоо

Хуулийн этгээдийн нэг ажилтны цалинг аж ахуй нэгж, байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалингаар буюу сүүлийн зургаан жилийн /2020-2025 он/ дундаж цалингийн хэмжээ болох 1,824.2 мянган төгрөгөөр тооцоолов.

Хүснэгт 2. Сүүлийн зургаан жилийн /2020-2025 он/ дунджаар тооцоолсон аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин, мян.төг

Он	2020	2021	2022	2023	2024	2025	Зургаан жилийн дундаж
Улсын дундаж цалин ⁴ , мян.төг/сар	1,220.6	1,279.4	1,503.8	1,881.8	2,332.4	2,726.9	1,824.2

Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д долоо хоногийн ердийн ажлын цаг 40-өөс илүүгүй, 84.2-т ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 цагаас илүүгүй байхаар тус тус зохицуулсан байдаг. Иймд ажилтан сард дунджаар ажлын 21 өдөр⁵ ажилладаг гэвэл энэ нь 168 цаг (21 өдөр x 8 цаг/өдөр) буюу 10080 минут (168 цаг x 60 мин/цаг)-тай тэнцэж байна.

Хүснэгт 3. Аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй ажилтны ажлын 1 цаг болон 1 минутын хөлс

Сарын дундаж цалин, төгрөг	Сард дунджаар ажиллах хугацаа	Ажлын хөлс, төгрөг
1824150	168 цаг	Ажлын 1 цагийн хөлс 10858
	10080 минут	Ажлын 1 минутын хөлс 181

Ажилтны ажлын 1 минутын хөлсийг 181 төгрөг байхаар тооцсон.

Хүснэгт 4. Хуулийн этгээдэд үүсэх зардал

Үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуул ах хугацаа,	Ажлын хөлс, төгрөг/минут	Зардал, төгрөг
-------	---------	------------------------	---------------------	--------------------------	----------------

⁴ <https://1212.mn/> . Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин, Улсын дундаж жилээр

⁵ ХНХ-ын сайдын 2021 оны 12-р сарын 06-ны өдрийн А/192 тоот тушаалаар баталсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын “1.6.Хуанлийн жилийн сарын дундаж ажлын өдрийг 21 өдрөөр, нэг сарын дундаж ажлын цагийг 168 цагаар тооцож болно”.

			минут			
Ажилд зуучлах үйлчилгээ эрхлэхтэй холбоотой мэдээ, мэдээлэл холбогдох төрийн байгууллагаас авах	Ажилд зуучлах үйлчилгээ эрхлэхтэй холбоотой мэдээ, мэдээлэл холбогдох төрийн байгууллагаас авах	Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	2	181	362	
		Олшруулах, архивлах	5	181	905	
	Ажил хайгчийн хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ хийх	Үнэлгээ хийх	60	181	10860	
		Танилцуулах	30	181	5430	
		Баталгаажуулах	30	181	5430	
	Хөдөлмөр/бизнес эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах, хянах	Мэдээллийн өгөгдөхүүнийг шалгах	45	181	8145	
		Дотоод хуралдаан	30	181	5430	
		Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	2	181	362	
		Олшруулах, архивлах	5	181	905	
	Ажилд зуучлах үйлчилгээ эрхлэхтэй холбоотой мэдээ, мэдээлэл холбогдох төрийн байгууллагаас авах, ажлын байранд зуучлах талаар ажил олгогчтой хэлэлцээ хийх, ажил хайгчийг ажилд зуучлах, үйлчилгээ ний явцад гарсан маргаан, саналыг шийдвэрлэх	Зуучлалын үйлчилгээний явцад гарсан маргаан, саналыг шийдвэрлэх,	Мэдээллийн өгөгдөхүүнийг шалгах	5	181	905
			Дотоод хуралдаан	30	181	5430
			Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	2	181	362
			Олшруулах, архивлах	5	181	905
			Дүгнэлт гаргуулах	15	181	2715
			Шаардлагатай бол холбогдох эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх	30	181	5430
			Тайлан бэлтгэх	15	181	2715
	Хөдөлмөр эрхлэхэд зуучилсан талаар мэдээлэл өгөх, зохих журмын дагуу хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнах	Хөдөлмөр эрхлэхэд зуучилсан талаар мэдээлэл өгөх, зохих журмын дагуу хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнах	Мэдээллийн өгөгдөхүүнийг шалгах	5	181	905
			Дотоод хуралдаан	30	181	5430
			Олшруулах, архивлах, тараах	5	181	905
			Мэдээлэл шилжүүлэх, нийтлэх	2	181	362
Нийт зардал					63893	

Хуулийн этгээдэд үүсэх зардлын хэмжээ 63893 төгрөг байна.

Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Энэ хэсэгт зардлыг нь тооцсон үүрэг нэг бүрийн зардлыг бууруулах, аж ахуйн нэгжид үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг дараах шалгуур ашиглан шалгалаа:

- ✓ Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх: Мэдээллийг 100% цахим хэлбэрээр хүргүүлэх, бичиг баримтын үнэн зөв байдлыг цахим хэлбэрээр шалгах боломжийг судлах шаардлагатай байна.
- ✓ Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ үзүүлдэг төрийн захиргааны байгууллагын тоо тогтмол байдаг. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ үзүүлдэг хувийн байгууллагын тоо харьцангуй тогтмол юм. Харин ажил хайгчдын тоо тогтмол биш бөгөөд сүүлийн зургаан жилийн дунджаар нэг жилд 33368 хүн ажилд зуучлагдсан байна. Ажил зуучлалд хамрагдах хүний тоо тухайн жилээс хамааран багасах эсхүл нэмэгдэх боломжтой.
- ✓ Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх: Хуулийн этгээд нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ үзүүлэхийн тулд зайлшгүй хэлэлцээ хийх үүрэгтэй байна. Энэ үүрэг нь заавал хийгдэх үйл ажиллагаа тул давтамжийг багасгах боломжгүй.

1.3. Үр дүн, санал

Хуулийн нийт этгээдэд үүсэх нийт зардлын хэмжээ нь 1 байгууллагад 63893 төгрөг байхаар урьдчилсан тооцоо гарч байна.

ХОЁР. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Энэ бүлэгт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр төрийн байгууллагад үүрэг ногдуулсан зохицуулалтууд нь тухайн байгууллагад хэдий хэр ачаалал, зардал үүсгэх магадлалтайг баримжаалан тооцоолох зорилготой.

Төрийн байгууллагад буюу улсын төсөвт үүсэх зардлыг урьдчилсан байдлаар тооцоолох ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалын дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ.

Үүнд:

1. Төрийн захиргааны байгууллагад хүлээлгэсэн үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлох;
2. Гарах зардлыг урьдчилан тооцоолох;
3. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах;
4. Үр дүн, санал.

2.1. Төрийн байгууллагад хүлээлгэсэн үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлох

ХЭДтХ-ийн шинэчилсэн найруулгын төсөлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудад нэмэлтээр зардал шаардагдахгүй бөгөөд батлагдсан орон тоо, төсвөөр ажиллахаар тооцсон.

Хуулийн төслийн 31 дүгээр зүйлд дурдсан “Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл” нь орон тооны бус гишүүдээс бүрдэх бодлогын зөвлөл байх бөгөөд нэмэлтээр зардал шаардагдахгүй.

Хүснэгт 5. Үүрэг хүлээх байгууллагууд болон тэдгээрийн гүйцэтгэх үүрэг

Субъект	Гүйцэтгэх үүрэг
Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл	Хуулийн төслийн 31 дүгээр зүйлд Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн бүрэн эрхийг өмнөх хуулийн 28.8 дахь заалтыг өргөжүүлж нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар тодорхойлж өгсөн. Зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.
Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хуулийн төслийн 32 дугаар хэсэгт хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаарх чиг үүргийг дэлгэрүүлэн тусгасан.
Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	Хуулийн төслийн 33 дугаар зүйлд хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний зохион байгуулалтыг хангах хүрээнд гүйцэтгэх чиг үүргийг өргөжүүлэн тодорхойлсон.
Хөдөлмөрийн судалгаа, шинжилгээ, салбарын хүний нөөцийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага	Хуулийн төслийн 34 дүгээр зүйлийн 34.1-д Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллах судалгаа, шинжилгээ, салбарын хүний нөөцийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагыг тогтмол болон захиалгат судалгаа, шинжилгээ, сургалт, хөгжлийн ажил хийж, бодлогын санал зөвлөмж боловсруулж, мэдээллээр хангахаар заасан.
Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан	Хуулийн төслийн 35 дугаар зүйлд аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтны хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлсон.
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	Хуулийн төслийн 36 дугаар зүйлд аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагааны хүрээний бүрэн эрхийг тодорхойлон тусгасан.
Засаг дарга	Хуулийн төслийн 37 дугаар зүйлд аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны Засаг даргын хөдөлмөр эрхлэлтийн хүрээний бүрэн эрхийг тодорхойлон тусгасан.
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч хувийн болон мэргэжлийн бусад байгууллага	Хуулийн төслийн 38.1 дэх хэсэгт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч нь хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага, мэргэжлийн бусад төрийн, төрийн бус байгууллага, иргэн байхаар зохицуулсан. Хуулийн төслийн 38.2 дахь хэсэгт хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан 38.1-т ззасан шаардлага хангасан, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоонд бүртгүүлсэн байгууллага, иргэнээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг гэрээлэн гүйцэтгүүлж болох талаар нарийвчлан тусгасан.
Нийгмийн түншүүд	Хуулийн төслийн 41 дүгээр зүйлд ажилтан болон ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн нийгмийн түншлэгч байгууллагын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангахтай холбоотой чиг үүргийг шинээр тодорхойлж өгсөн.

2.2. Зардлын тооцоо

Төрийн байгууллагууд одоогийн батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан хуулийн хэрэгжилтийг хангах боломжтой. Шинээр орон тоо нэмэхгүй учир зардал нэмэгдэхгүй.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, ажилтан нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зорилтот бүлгийн иргэний хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай тохиолдолд кейс менежментийн аргачлалыг ашиглана гэж зааж өгсөн.

Иргэнд кейс менежментэд тулгуурласан үйлчилгээ үзүүлэхэд хоёр төрлийн загварыг хэрэглэдэг ба загвар бүрээр гарах зардлын төрөл нь дараах байдалтай байна:

Загвар	Тайлбар	Зардал, төрөл
1. Дотоод нөөцөд тулгуурласан үйлчилгээний загвар: Кейс менежерүүдийг Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын ажилтнаар ажиллуулах	Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад “кейс менежер”-ийн байнгын орон тоог бий болгох, тогтвортой ажиллуулахтай холбоотой зардал байх	Цалин, урамшуулал - Байнгын ажилтны тогтмол зардал Сургалт, хөгжлийн зардал - Ажилтны мэргэжил, ур чадвар дээшлүүлэхэд шаардагдах зардал буюу сургалтын хөтөлбөр боловсруулах, багш, зөвлөх ажиллуулах, давтан сургалт, төрөл бүрийн бэрхшээлийг ойлгох чадварт суралцах ажлын зардал багтах Ажлын байр, хүртээмж - Үйлчлүүлэгчийн онцлог, хэрэгцээнд нийцсэн ажлын байрны тохижилт, тохируулга хийх зардал Тоног төхөөрөмж, хэрэгсэл - Ажлын байрны хэрэгсэл буюу компьютер, тоног төхөөрөмж, үйлчлүүлэгчийн онцлог, хэрэгцээнд зориулсан туслах техник технологи, мэдээллийн систем зэргийн зардал багтах
2. Гэрээлэн гүйцэтгүүлэх загвар: Төрийн бус байгууллага, эсвэл хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай гэрээ байгуулж ажиллуулах	Зардал нь “кейс менежер” гэсэн ажилтны зардлаас илүү “гэрээлэн гүйцэтгүүлэх ажлын зардал”-д төвлөрнө.	Холбогдох зардал нь гаднын байгууллагатай гэрээ байгуулах үйл явц, бүтэн зохион байгуулалттай холбоотой гарах зардал байна. Үүнд: - Худалдан авах үйл ажиллагааны зардал (тендер зарлах, санал авах, үнэлэх, гэрээ байгуулах ажил багтах) - Гэрээний дүн буюу зөвлөх үйлчилгээний хөлс

Олон улсын хэмжээнд 1 кейс менежерийн сарын дундаж үйлчлүүлэгчийн тоо 150, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын нийт үйлчлүүлэгчдийн ойролцоогоор 30.0 хувьд (хөдөлмөрийн дутуу ашиглалт 139.9 мян.хүн (2020-2025 оны дундаж)-ий 30.0 хувь нь 41.9 мян.хүнтэй тэнцэх) кейс үүсгэж ажилладаг гэсэн үндэслэлд нийцүүлэн зардлын тооцоог хийвэл дараах байдалтай байна.

- Кейсийн тоо 41.9 мянган хүн ÷ 150 = 279 кейс менежер ажиллах (улсын хэмжээнд) × 1,824.2 мян.төг (сарын дундаж цалин) = нэг сард кейс менежерийн ажлын хөлсөнд 508,951.8 мян.төгрөг зарцуулахаар тооцоологдсон.

Хоёр загварын алыг ч ашигласан үед хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад орон тоо нэмэгдэх шаардлагагүй. Дотоодын нөөцөд тулгуурласан загварын тухайд одоогийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын ажилтнуудаас кейс менежерийг бэлтгэж сургах, ажиллуулах замаар шийдвэрлэх боломжтой. Гэрээлэн гүйцэтгүүлэх загвар нь гадны байгууллагын ажилтан ажиллах тул хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын хүний нөөцөд нөлөөлөхгүй.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд кейс менежментийн аргачлалыг нэвтрүүлсэнээр ганцаарчилсан үйлчилгээнд зарцуулах зардал нэмэгдэх талтай ч “бүлгийн зөвлөх үйлчилгээ” болон “санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ” зэргийг тодорхой зорилтот бүлэгт төвлөрөн үзүүлэхээр тусгасан учраас нийт төсөвт нөлөө үзүүлэхгүй.

Хуулийн төсөлд шинэ зохицуулалтаар тусгасан “дагалднаар ажиллахыг дэмжих”, “дагалднаар суралцахыг дэмжих” арга хэмжээний хүрээнд зорилтот бүлгийн иргэнийг 3 сараас багагүй хугацаагаар ажиллуулсан ажил олгогчид урамшуулал олгох юм. Өөрөөр хэлбэл ажил олгогчийн хүний нөөцийн зардалд дэмжлэг үзүүлэхийн сацуу хөдөлмөр эрхлэхэд саад бэрхшээлтэй, ажилгүй зорилтот бүлгийн иргэний тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой арга хэмжээ юм. Уг зохицуулалтаар арга хэмжээнд хамрагдах үр шим хүртэгчийн хамрах хүрээ өргөжиж байгаа хэдий ч урамшууллын хэмжээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хуулийн холбогдох зохицуулалтаас 4 дахин богиносч гурван сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэхээр байгаа тул нийт төсөвт нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

Дагалднаар суралцахыг дэмжих нь Хөдөлмөрийн тухай хуулийн 63.1-т заасан гэрээнд үндэслэн ажил олгогч болон ажилтан буюу мэргэжлийн, техникийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчаас төлөх 6 хүртэлх сарын хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төлөх арга хэмжээ юм.

Өнгөрсөн хугацаанд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухайн жилийн нийт төсвийн 70-аас дээш хувийг хувиараа хөдөлмөр эрхлэх, нөхөрлөл хоршоо байгуулах иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг үзүүлэх, жижиг зээл олгох арга хэмжээнд зарцуулдаг байсан.

Хуулийн төсөлд хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогын арга хэмжээнүүдийг иргэн төвтэй болгож, жигд хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарч байна. Ялангуяа ажилгүй хүн, зорилтот бүлгийн иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, мэргэжилтэй, ур чадвартай болгох, ажлын байранд дадлагажуулж тогтвортой ажилтай болоход чиглэсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, санхүүжилтийг хүртээмжтэй болгохы зорьж байна.

Иймд хуулийн төсөлд туссан дагалднаар суралцахыг дэмжих зэрэг шинэ төрлийн үйлчилгээ, арга хэмжээний зардалтай холбоотой нэмэлт төсөв шаардагдахгүй, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийг үйлчилгээ, арга хэмжээ бүрээр тэнцвэртэй хуваарилж хэрэгжүүлдэг болох юм.

Бусад зардал

Бусад зардалд төрийн байгууллагаас тухайн ажил үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой дагалдан гарах зардлыг авч үзнэ. Тухайлбал байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэх, тусгайлсан

програм хангамж боловсруулах, тендер зарлах гэх зэрэг зардлыг дурдаж болох юм.

Мөн цахим болон цаасан материалыг агуулах, түүнийг удирдах програм болон бусад тоног төхөөрөмж, хэрэгсэл нэн даруй шаардлагатай болно.

Програм хангамж, технологийн шинэчлэл хийх тухайд цаасан нотлох эх баримтыг цахимжуулах, онлайн горимд шилжүүлж, иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг ил тод, нээлттэй, шуурхай, хүртээмжтэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах зэрэгт нийт 500 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай болно.⁶

Төрийн байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны цар хүрээнээс хамааран хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэхэд⁷ дунджаар 100 сая төгрөг зарцуулдаг.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан үүрэг буюу ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд дараах бусад зардал гарна гэсэн төсөөллөөр бусад зардлыг тооцлоо. Үүнд:

Хүснэгт 6. Бусад зардлын хэмжээ

Зардлын нэр	Зардлын хэмжээ, төгрөг/жил
Хөндлөнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ	100 000000
Програм хангамж, технологийн шинэчлэл хийх	500 000000
Нийт	600 000000

Дээрх хүснэгтээс харахад хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад жилд 600.0 сая төгрөгийн зардал үүсэхээр байна.

2.3. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Хуулийн төсөлд шинээр нэмэгдэж байгаа буюу өөрчлөгдөж буй зохицуулалттай холбоотой төрд үүсэх зардлыг хэрхэн багасгах, эдийн засагт дарамт багатай өөр хувилбар боломж байгаа эсэхийг нягталж үзлээ.

Хувилбарыг нягтлах ажлыг дараах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу гүйцэтгэв. Үүнд:

1. Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;
2. Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх;
3. Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх;
4. Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;
5. Мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх.

- ✓ Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх: Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагыг цаасан эх баримтаар бүртгэхийн зэрэгцээ цахим хэлбэрээр давхар бүртгэх. Аливаа бүртгэл нь хувь хүний болон албан

⁶ “УБЕГ-ын үйл ажиллагааны төвшинд бүх бүртгэлийг цахим горимд бүрэн шилжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд үүний 4,5 сая нь програм хангамж, 4,5 тэрбум нь сервер, техник хэрэгсэл авахад шаардлагатай, харин шинэчлэн боловсруулахад дунджаар 500 сая төгрөг байдаг жишгээр тооцлоо.

⁷ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 4-р сарын 17-ны өдрийн А/45 тоот тушаалаар батлагдсан “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”-ын дагуу жил бүр байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэх үүрэгтэй.

байгууллагын эд хөрөнгө, эрх ашигтай шууд холбогддог, маргаан үүсэх тохиолдолд нотлох баримтаар ашиглагдах зэрэг эрх зүйн чухал ач холбогдолтой нотлох эх баримт бичиг юм. Иймд тэдгээрийг нягтлах, үнэн, бодит байдлыг шалгах зэрэг ажиллагаанд ажилтны үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай. Учир нь баримт бичгийг хуурамчаар үйлдэх үйлдэл цөөнгүй гардаг тул эдгээр баримт бичгийг албан ёсны эх сурвалжтай тулгах, нягтлах шаардлага үүсдэг. Харин бүртгэлээс лавлагаа мэдээлэл хүсэх, мэдээлэлд өөрчлөлт оруулах, хүсэлт ирүүлэх, тэдгээрт хариу өгөх замаар баримт бичгийн бүрдүүлэлтийг бүрэн, зөв, гүйцэд болгох зэрэг ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх нь бүртгэлийн газарт үүсэх дараалал, ажлын ачааллыг бууруулах, хуулийн этгээд, иргэн нь шаардлагатай мэдээллээ бүрэн авснаар олон дахин очихгүй байх зэрэг давуу тал үүсэх юм.

- ✓ Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх: Хуулийн этгээдийн бүртгэлд хамрагдах этгээдийн тоо ажилд зуучлуулах иргэдийн тооноос хамааран хэлбэлзэх магадлалтай.
- ✓ Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх: Хуулийн төсөлд зааснаар мэдээлэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах зэрэг хуулийн дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагааны давтамжийг бууруулах боломжгүй.
- ✓ Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх: Хуулийн этгээд, иргэнийг бүртгэх, мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэх, бүртгэлээс хасах хүсэлт гаргах тохиолдолд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг нэмж оруулсан нь түүнийг бүртгэх, өөрчлөлт оруулах ажилтны ажил үйлчилгээний хэмжээг нэмэгдүүлсэн байна. Гэхдээ хуулийн этгээд, иргэний хувийн хэрэгт хавсаргаж буй баримт бичгүүд нь эх нотлох баримт болдог тул төрийн байгууллагын үйл ажиллагаанд “үл маргах” нотлох баримт болох нөхцөлийг бүрдүүлэх тул мэдээллийн агуулгыг багасгах шаардлагагүй.
- ✓ Мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх: Хуулийн төсөлд хуулийн этгээд, иргэний бүртгэл хөтлөх үйл ажиллагааны наад захын шаардлагыг тогтоосон зохицуулалт орсон байх тул энэ тохиолдолд агуулгаас татгалзах асуудал хөндөгдөхгүй. Эсхүл программ шинэчилсэн тохиолдолд мэдээллийн агуулгыг зөвхөн цахимаар аван, шинэчлээд явах боломжтой.

2.4. Үр дүн, санал

Хүний нөөцийн нэмэлт, хэрэгцээ шаардлага үүсэхгүй, батлагдсан орон тоо, төсөвт багтаан хэрэгжүүлэх боломжтой.

ГУРАВ. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсаны дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдах иргэний тухайд хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийв.

Аргачлалд зааснаар иргэний зардал, ачааллыг тооцох ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

1. Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
2. Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
3. Тоон үзүүлэлтийг тооцох;
4. Нийт дүнг тооцож гаргах;
5. Хялбарчлах боломжийг шалгах.

Иргэний зардлыг тооцохдоо мөнгөн зардлаас гадна зарцуулах хугацаа (ачаалал)-г тооцно.

3.1. Иргэнд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зааснаар иргэн ажил хайгчаар бүртгүүлэх, аж ахуй эрхлэхэд дэмжлэг авах хүсэлтээ гаргах үүрэг хүлээлгэжээ.

3.2. Зардлын тооцоо

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр иргэнд үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргав. Иргэний зүгээс үүргийг хэрэгжүүлэх хүрээнд хийх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлж, тус бүрт зарцуулах хугацаа ачаалал болон мөнгөн зардлыг тогтооно.

Үүнд:

1. Үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлох;
2. Тухайн үйлдэлд зарцуулагдах хугацааг тогтоох;
3. Тухайн үйлдлийг хийхэд иргэнээс гарах зардлыг тодорхойлох.

3.2.1. Иргэн ажилд зуучлуулах, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамрагдах, хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэг хүсэхэд үүсэх зардал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах зорилтот бүлгийн хүн ам, иргэн үйлчилгээ авах эрх зүйн үйлчлэл чиглэх этгээд байна.

Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хичнээн иргэнд, нэг жилд хэдэн удаагийн давтамжтайгаар тухайн үүргийг хүлээлгэж байгааг илэрхийлнэ.

Тохиолдлын тоо: Иргэн тус бүрээр тооцох тул нэг иргэнээр жишээлэн зарцуулах хугацааг тооцов.

Иргэнд үүсэх нийт ачааллыг тооцох

Энэ хэсэгт стандарт үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэхтэй холбогдон зарцуулах хугацаа болон тоон үзүүлэлтийг хооронд нь үржүүлж нийт ачааллыг гаргана.

Хүснэгт 7. Нийт ачааллын хэмжээ

Иргэний үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа, Минут	Тоон үзүүлэлт	Нийт ачаалал, минут
Шаардлагатай бичиг баримтыг гэрчлэх баталгаажуулах	Бичиг эхийн хуулбар	1	1	1
Баталсан маягтын дагуу өргөдөл гаргах	Нотариатаар баталгаажуулах	20	1	20
Шаардлагатай бол холбогдох эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх	Олшруулах, архивлах, тараах	3	1	3
Баталсан маягтын дагуу	Өргөдөл бичих	7	1	7

өргөдөл гаргах				
Шаардлагатай бол холбогдох эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх	Төрийн эрх бүхий байгууллагаар шалгалт хийлгэх	15	1	15
Гэрчлэх баримтыг баталгаажуулах	Нотариатаар баталгаажуулах	20	1	20
Хүргүүлэх	Олшруулах, архивлах, тараах	3	1	3
Нийт ачаалал				69

Үр дүн, санал

Хуулийн төсөлд тусгасан үйл ажиллагаагаар иргэнд хариуцуулсан үйл ажиллагаанд зарцуулах цаг нэг хүний 69 минут байна. Хэрэв бичил бизнесийн төсөл боловсруулахаар бол энэ цаг нэмэгдэнэ.

3.3. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Энэ хэсэгт тодорхой шалгах асуултын дагуу зардлыг нь тооцсон үүрэг нэг бүрийн зардлыг бууруулах, иргэнд үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгалаа.

- ✓ Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой байна.

3.4. Үр дүн, санал

Хэрэгцээ, шаардлагын судалгаанаас үзэхэд иргэнд үүсэх зардлын хувьд нэмэлт ачаалал үүсэхээргүй байна.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. Ажилд зуучлах үйлчилгээ эрхлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах зэрэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ үзүүлэхэд хуулийн этгээдэд жилд нэг иргэнээр тооцоход 54362 төгрөгийн зардал үүсэхээр байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ хариуцсан төрийн захиргааны байгууллагууд, түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагуудын үйлчилгээний зардлыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас үргэлжлүүлэн санхүүжүүлнэ.

2. Дагалдан ажилтанд шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэх сургалтыг мэргэжлийн сургалтын байгууллагаар дамжуулан зохион байгуулж, сургалтын зардлыг ажил олгогчийн хүсэлтийг үндэслэн Ажилгүйдлийн даатгалын сангаас санхүүжүүлж болно.

3. Нэгтгэн дүгнэхэд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан зохицуулалтаас нэмэлт зардал үүсэх нэгж нь төрийн байгууллага байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг. Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль, legalinfo.mn
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн баталсан “Эх дэлхийгээ шинэчилье 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөр”
- Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын “Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай” 122 дугаар конвенци, түүнийг дагалдаж гарсан “Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай” 122 дугаар зөвлөмж, Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга замын талаарх санал, “Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай (Нэмэлт зүйлүүд)” 169 дүгээр зөвлөмж;
- Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын “Хөдөлмөр эрхлэлтийн албаны тухай” 88 дугаар конвенци, “Хөдөлмөр эрхлэлтийн албаны тухай” 83 дугаар зөвлөмж;
- Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын “Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай” 181 дүгээр конвенци, “Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай” 188 дугаар зөвлөмж;
- Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын “Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих гурван талт зөвлөлдөөний тухай” 144 дүгээр конвенци, “Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих гурван талт зөвлөлдөөний тухай” 152 дугаар зөвлөмж;
- Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын “Далайн хөдөлмөрийн тухай” 2006 оны конвенци.
- “Хөдөлмөрийн ирээдүйн тухай” ОУХБ-ын Зууны тунхаг, https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_724946.pdf
- Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль
- Ахмад настны тухай
- Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хууль
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль
- Төв Банк /Монголбанк/-ны тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа – 2050” баримт бичиг
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”

- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”

Хоёр. Ном зохиол, судалгааны тайлан, цахим мэдээлэл

Монгол хэлээр:

- Гэрэлт ирээдүйн төлөө ажиллацгаая – Ирээдүйн хөдөлмөрийн тухай дэлхийн комиссын тайлан, Олон улсын хөдөлмөрийн товчоо – Женев хот: ОУХТ, 2019
- Д.Сүнжид. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын зардлын тооцооллын ажлын тайлан, 2020
- “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын үр дүнгийн шинжилгээ”, Судалгааны тайлан, Удирдлагын академи, Улаанбаатар, “Мөнхийн үсэг” ХХК, 2020 он
- Селин Ферре, “Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээний үнэлгээ-2020” судалгааны тайлан., Дэлхийн банк, ХНХЯ
- А. Гантуяа, “Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн жөндөрийн тэгш байдалд Ковид-19 цар тахлын үзүүлж буй нөлөө”, Фридрих-Эбертийн сан, 2020
- Монгол Улсын Хөдөлмөрийн зах зээл дэх “COVID-19” цар тахлын нөлөө, 2020 оны III, IV улирал, 2021 оны I, II, III улирал, ХНХЯ, ХНХСИ
- “Монгол Улсын албан бус хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал”, Судалгааны тайлан, ОУХБ, Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, 2021
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, ОУХБ. (2022). “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагаа, санхүүжилтийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ”, Судалгааны тайлан, “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” техник туслалцааны төсөл
- Дэлхийн Банк. (2022). “Монгол Улсын Хөдөлмөрийн зах зээлийн дүн шинжилгээ: Эдийн засгийг сэргээх, төрөлжүүлэх зорилгоор илүү идэвхтэй, хүртээмжтэй хөдөлмөрийн зах зээлийг бий болгох нь”, Нэгтгэл Тайлан
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, ОУХБ. (2023). “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн агуулга, үр дүнгийн үнэлгээ”, Судалгааны тайлан, “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” техник туслалцааны төсөл
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, 2024 оны 9 дүгээр сар

Гадаад хэлээр:

- Aurelio Parisotto., Nikhil Ray, Rethinking macroeconomic policies for full employment and inclusive growth: Some elements., ILO, 2017

- 'Challenges for achieving job-rich and inclusive growth in Mongolia', Per Ponnas, ILO, 2011
- Comparative review of unemployment and employment insurance experiences in Asia and worldwide /John Carter, Michel Bédard, Céline Peyron Bista; Promoting and Building Unemployment Insurance and Employment Services in ASEAN, ILO Regional Office for Asia and the Pacific. – Bangkok: ILO, 2013
- Guide for the formulation of national employment policies / International Labour Office, Employment Policy Department. - Geneva: ILO, 2012
- The Federal reserve act of 1913, V. Gilmore Iden, Published by the National bank news, PHILADELPHIA
- National employment policies for an inclusive, job-rich recovery from the COVID-19 crisis, ILO Brief
https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_emp/documents/publication/wcms_756676.pdf
- <https://www.arbeitsagentur.de/>

---000---